



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 73/
32-01

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2025 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн ДА-2025/04/ҮА-ОНА дугаартай удирдамжийн дагуу Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ын 2024-2025 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврыг мөрдөөгүй, ажил гүйлгээ гарсныг нотолж бичгээр бүрдүүлсэн болон бусад нотолгоог түүнийг үйлдсэн зөвшөөрсөн, шалгаж авсан ажилтны гарын үсгээр баталгаажуулаагүй баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан нийт 70,446,440.0 (Далан сая дөрвөн зуун дөчин зургаан мянган дөрвөн зуун дөчин мянган төгрөг)-ийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.5 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн букуу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно." 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" Сангийн сайдын 2017 оны 347 дугаар туаалын хавсралтаар батлагдсан" Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар"-уудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

4325007201

1. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх зааврыг мөрдөж, баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг бүртгэл тайлланд тусгахгүй байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ын дарга Ц.Уртнасан, Ерөнхий нягтлан бодогч Б.Гандөл нарт даалгав.
3. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Т.ОДСҮРЭН



ЗӨВШӨӨРСӨН:

ТӨГӨЛДӨР ЕРӨӨ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.УРТНАСАН



ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.ГАНДӨЛ

Б.ГАНДӨЛ